

“Иргэдийн оролцоо-Хотын маргааш” Монголын анхны зөвлөлдөх санал асуулга: Эхний үр дүн

Ерөнхий мэдээлэл ба тойм

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын оршин суугчдын дотроос шинжлэх ухааны үндэслэлтэй санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон иргэд 2015 оны 12-р сарын 12-13 өдрүүдэд цуглан хоёр хоногийн турш хотын мастер төлөвлөгөөнд тусгагдсан томоохон дэд бүтцийн төслүүдийн талаар зөвлөлдөв. Хөтөлбөрийн дагуу иргэд жижиг бүлгийн хэлэлцүүлэгт оролцохын зэрэгцээ нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр зээлээр санхүүжих 14 томоохон төслүүдийн эерэг, сөрөг талуудын талаар мэргэжилтэн шинжээчдээс асуулт асууж нэмэлт мэдээлэл авсан. Энэхүү Зөвлөлдөх санал асуулгын төслийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э. Бат-Үүл болон ноён Г. Занданшатар нараар удирдуулсан Зөвлөх хороо хэрэгжүүллээ. Зөвлөх хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд улс төр, бизнес, иргэний нийгмийн салбарын нэрт зүтгэлтнүүд багтсан болно. (Хавсралт А-аас харна уу).

Хэн оролцсон бэ? Анхан шатны судалгааг бүлэглэсэн (судалгаанд оролцогчдыг дүүрэг, амьдарч буй сууцны төрөл, хүйс, насны бүлгийн төлөөллийг харгалзан) санамсаргүй түүврийн аргаар сонгосон 1502 иргэдээс авсан. Эдгээр судалгаанд оролцох иргэдийг санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон өрхүүдийн судалгаанд хамрагдах гишүүдээс санамсаргүй түүврийн аргаар сонгосон юм. Санал асуулгад нийслэл хотын бүх бүс нутгийг хамруулсан бөгөөд орон сууц ба гэр хороолол аль аль нь багтсан юм¹. Анхан шатны санал асуулгад хамрагдсан иргэдээс зөвлөлдөх арга хэмжээнд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн 400 оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгож урилга тараасан. Үүнээс дор хаяж 300 оролцогчдыг зөвлөлдөх санал асуулгын арга хэмжээнд бүрэн оролцуулах зорилготой байсан юм. Урилга тараахын өмнө анхан шатны дэлгэрэнгүй санал асуулга явуулсан тул хоёр өдрийн зөвлөлдөөний арга хэмжээнд бүрэн оролцсон 317 оролцогчид хандлага болон хүн ам зүйн хувьд анхан шатны санал асуулгад хамрагдсан үлдсэн 1185 оролцогчидтой харьцуулах боломжтой юм. Хавсралт В нь хоёр өдрийн зөвлөлдөөнд хамрагдсан оролцогчид болон анхан шатны санал асуулгад хамрагдсан бусад оролцогчдын хооронд хүн ам зүйн хувьд мэдэгдэхүйц ялгаа маш бага байсныг харуулж байна. Хүйс, боловсрол, нас, хөдөлмөр эрхэлсэн байдал, гэр бүлийн байдал болон орлогын хэмжээний хувьд мэдэгдэхүйц ялгаа байгаагүй. Амьдарч буй сууцны төрлийн хувьд гэр хороолол болон олон нийтийн байранд оршин суудаг иргэд жаахан илүү байсан бөгөөд урт хугацааны оршин суугчид харьцангуй цөөн байсан байна (11 болон түүнээс дээш оршин суусан). Санал болгож буй 14 төслийн хувьд бодлогын хандлагыг авч үзвэл 317 оролцогчид болон оролцоогүй 1185 иргэдийн хувьд бага зэргийн л ялгаа ажиглагдсан (Хавсралт Г). Санал асуулгыг явуулсан байгууллага болох Эм Эм Си ЖИ компанийн өндөр түвшинд гүйцэтгэсэн ажлын үр дүнд амралтын өдрүүдээр Төрийн Ордонд зохион байгуулагдсан Зөвлөлдөх санал асуулгад Улаанбаатар хотын оршин суугчдын бичил нэгж цугларч чадсан болно.

Юу болсон бэ? Зөвлөлдөөнд оролцогчид цугласаны дараагаар тэднийг санамсаргүй түүврийн аргаар 15 орчим гишүүдийн бүрэлдэхүүнтэй бүлгүүдэд хуваасан бөгөөд эдгээр бүлгүүд санал болгож буй төслүүдийн талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн. Зориг сангийн сонгон шалгаруулалтанд тэнцэн, холбогдох сургалтанд хамрагдсан Модераторууд иргэд танилцуулга материалд тусгасан

хөтөлбөрийн дагуу бүх төслийг хэлэлцэх үйл явцад туслаж, чиглүүлж ажилласан. Модераторууд хэлэлцүүлгийн явцад өөрсдийн санал бодлыг илэрхийлэхгүй байх тал дээр сургалтанд хамрагдсан. Тэдний гүйцэтгэх үүрэг нь санал болгож буй төслүүдийн эерэг болон сөрөг талуудын талаар хэлэлцэх явцад оролцогчид эрх тэгш, харилцан хүндэтгэлтэйгээр оролцох байдлыг хангах байсан. Жижиг бүлгийн хэлэлцүүлгийн эцэст оролцогчид нэгдсэн хэлэлцүүлгийн явцад мэргэжилтэн шинжээчдэд тавих гол асуултууд дээр санал нэгдэн тохиролцох зорилготой байсан. Энэхүү хоёр өдрийн арга хэмжээний явцад жижиг бүлгийн хэлэлцүүлэг болон нэгдсэн хэлэлцүүлэг ээлжлэх зарчмаар санал болгож буй бүх 14 төслийг хэлэлцсэнээр дууссан. Хоёр өдрийн хэлэлцүүлгийн эцэст оролцогчид хамгийн анх бөглөсөн асуумжийг дахин бөглөж хариулсан.

Санал болгож буй 14 төслийг зөвлөлдөөний өмнө болон дараа яг ижил үнэлгээний дагуу эрэмбэлсэн. Тиймээс эцсийн үр дүнд нь төслүүдийн эрэмбэ дарааллыг 0-ээс (огт хэрэггүй буюу огт хүсээгүй) 1 (хамгийн хэрэгтэй буюу хамгийн ихээр хүссэн) онооны хооронд үнэлсэн бөгөөд 0.5 нь яг дунд оноог илэрхийлнэ. Иргэдийн санал бодлыг авч үзвэл арга хэмжээний өмнө ч дараа ч бүх санал болгож төслүүдийг хэрэгтэй гэж үзсэн байна. Зөвлөлдөөний дараагаар санал болгож буй төслүүдийн үнэлгээ бүгд 0.644 гэсэн үзүүлэлтээс багагүй байна. Эдгээр төслүүд бүгд олон жилийн турш хийсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд санал болгож байгаагаас гадна маш чухал олон нийтийн асуудлуудыг шийдэхэд чиглэсэн төслүүд учраас ийнхүү өндөр үнэлгээтэй байгаа нь гайхах зүйлгүй юм. Тэгсэн хэдий ч зөвлөлдөөний дараагаар мэдэгдэхүйц өөрчлөлтүүд ажиглагдсан болно. Нийт 14 төслийн 8 төслийн үнэлгээ мэдэгдэхүйц өөрчлөгдсөн бөгөөд үүнээс 5 төслийн үнэлгээ буурч 3 төслийн үнэлгээ өссөн байна. Төслүүдийн эрэмбэ дараалал болон оролцогдын санал бодлын өөрчлөлтийг Хүснэгт 1-д харуулав. Хэлэлцүүлгийн өмнөх болон дараах санал асуулгын дэлгэрэнгүй үр дүнг Хавсралт Б-д танилцуулав.

Хүснэгт 1: Санал болгож буй төслүүд, Зөвлөлдөөний үр дүнгийн дагуу эрэмбээр жагсаасан

	Хугацаа1	Хугацаа2	Хугацаа2-Хугацаа1	Ач холбогдлын түвшин
1. Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан техникийн шинэчлэлт (2)	0.942	0.945	0.006	0.527
2. Туул, Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах (1)	0.954	0.936	-0.018	.091*
3. Эко парк байгуулах (3)	0.921	0.923	0.002	0.862
4. Барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк (Налайх) (10)	0.759	0.887	0.127	.000***
5. Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк (6)	0.84	0.88	0.04	.018**
6. Угсармал орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах (5)	0.874	0.835	-0.039	.018**

	Хугацаа1	Хугацаа2	Хугацаа2-Хугацаа1	Ач холбогдлын түвшин
7. Бага тойруугийн хуучин барилгыг буулган шинэчлэн барилгажуулах (8)	0.787	0.793	0.006	0.753
8. Туул усан сан – далан цогцолбор (4)	0.897	0.773	-0.123	.000***
9. Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах (13)	0.705	0.759	0.054	.005***
10. Монгол наадам цогцолбор (9)	0.76	0.741	-0.02	0.406
11. Туул хурдны зам (12)	0.738	0.735	-0.003	0.912
12. Улаанбаатар хотыг хийн түлшээр хангах (14)	0.664	0.689	0.025	0.301
13. Улаанбаатар метро (11)	0.742	0.67	-0.071	.003***
14. Экологийн коридор байгуулах (7)	0.795	0.644	-0.151	.000***

*Тэмдэглэл: Дээрх санал асуулгын үр дүн нь зөвлөлдөөний өмнө болон дараах үнэлгээний дундаж бөгөөд зөвлөлдөөний өмнөх болон дараах үнэлгээний ялгаа ба статистикийн мэдэгдэхүйц ялгааг агуулна. Статистикийн мэдэгдэхүйц ялгааны хувьд 0.01-с доош бол “***”, 0.05-с доош бол “**”, 0.1-с доош бол “*” гэсэн тэмдэглээгээр илэрхийлсэн. Зөвлөлдөөний өмнөх эрэмбийг төслийн нэрийн ард хаалтанд харуулсан.*

Иргэдийн үнэ цэнэ ач холбогдол өгч буй зүйлсийн талаарх эхний үр дүн

Иргэдээс авсан судалгаануудад өргөн хүрээг хамарсан асуултууд багтсан. Санал болгож буй 14 төслийг үнэлж эрэмбэлэхийн зэрэгцээ яагаад тодорхой төслүүдийг илүүд үзэж сонголт хийх болсоныг дэлгэрэнгүй ойлгоход чиглэсэн асуултууд мөн байсан. Түүнээс гадна иргэдийн засгийн газарт итгэх итгэл болон улс төр ба олон нийтийн хэлэлцүүлгийн талаарх үзэл бодлыг тодорхойлох зорилготой асуултууд мөн багтсан юм. Санал асуулгын энэхүү эхний үр дүнг зөвлөлдөх санал асуулгын арга хэмжээний үеэр хийгдсэн хэлэлцүүлгийн бичлэг болон протоколууд дээр тулгуурлан хийх дүн шинжилгээ улам нарийвлан гаргах болно. Зөвлөлдөх арга хэмжээний өмнө болон дараах санал асуулгын үр дүнгээс дараах эхний үр дүн гарав:

Байгаль орчинд анхаарал төвлөрүүлэх. Зөвлөлдөх арга хэмжээний дараах эрэмбэ дарааллын дагуу жагсаалтын эхний 6 төслийн 4 нь байгаль орчинтой холбоотой төслүүд байгаа бөгөөд цэвэр буюу нөхөн сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт болон хог хаягдал цуглуулахад чиглэсэн төслүүд байна. Хамгийн өндөр үнэлгээтэй болох “Сургууль цэцэрлэгийн барилгын дулаан техникийн шинэчлэлт” төслийн дундаж үнэлгээ нь 1-ээс 0.945 байна. Энэхүү төсөл нь төрийн өмчийн сургууль цэцэрлэгийн барилгуудын дулаан техникийн шинэчлэл хийхэд чиглэсэн юм. Хоёр дахь хамгийн өндөр үнэлгээтэй төсөл болох “Туул Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах” төсөл нь усны урсацыг

сэргээн сайжруулж, гол мөрний сав газрыг нөхөн сэргээх зорилготой. Зөвлөлдөөний дараа энэхүү төслийн дэмжлэг бага зэрэг буурсан хэдий ч 1-ээс 0.936 дундаж үнэлгээ авсанаар жагсаалтанд хоёрт эрэмбэлэгдсэн юм. Гуравт жагссан “Эко парк байгуулах” төслийн үнэлгээнд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй бөгөөд 1-ээс 0.923 үнэлгээ авсан байна. Жагсаалтын 6-р байранд “Угсармал орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах” төсөл 1-ээс 0.835 үнэлгээгээр орсон байна. Эдгээр үр дүн нь ард иргэдийн байгаль орчныг хамгаалахад өндөр ач холбогдол өгч буйг илэрхийлсэн санал асуулгын бусад асуултуудын хариултуудтай нийцэж байгаа юм. Хамгийн ихээр шаардагдаж буй бодлогын зорилтуудыг тодорхойлоход чиглэсэн цуврал асуултуудын үр дүнгээс харвал, зөвлөлдөөний дараа “цэвэр буюу нөхөн сэргээгдэх эрчим хүчээр хангах ба эрчим хүчний зарцуулалтыг бууруулах” зорилго 0.891 үнэлгээтэй, “усны хангамжийг сайжруулах” зорилго 0.963 үнэлгээтэй байсан бөгөөд зөвлөлдөөний өмнө болон дараа хамгийн өндөр үнэлгээтэй зорилтуудаар агаарын бохирдлыг бууруулах, усны бохирдлыг бууруулах ба газар хөрсний бохирдлыг бууруулах зорилтууд шалгарсан байна. Санал асуулгад багтсан нэг талаас байгаль орчныг хамгаалах, цэвэр байлгах нөгөө талаас хямд эрчим хүчний хангамжтай болох сонголт бүхий асуултанд хэрхэн хариулсанаас иргэдийн байгаль орчны талаарх үзэл бодол ямар хүчтэй байгааг мөн харах боломжтой. Зөвлөлдөөнд оролцогчдыг “байгаль орчинд сөрөг нөлөөтэй байсан ч” хямд эрчим хүчний хангамжтай болох уу эсвэл “эрчим хүч үнэтэй байсан ч” байгаль орчныг хамгаалах уу гэсэн сонголт хийлгэсэн байна. Үүний хариуд оролцогчдын дийлэнх нь эрчим хүчний үнэ өртөг өндөр байсан ч байгаль орчныг цэвэр хадгалан хамгаалах сонголтыг хийсэн байна (1-ээс 0.779 үнэлгээ авч зөвлөлдөөний дараагаар мэдэгдэхүйц өссөн байна.)

Хүн ам болон үйлдвэрлэлийн төвүүдийг олшруулах: Үнэлгээ нь эрс өссөн төслүүдийн гурав нь үйлдвэрлэл болон хөдөлмөр эрхлэлтийн төвлөрлийг сааруулж хотын төвөөс гаргахад чиглэсэн төслүүд байна. Налайх дүүрэгт байгуулагдах барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк төслийн үнэлгээ эрс өсч 0.887 хүрсэн бөгөөд жагсаалтанд 10-р байрнаас огцом дээшлэн 4-р байранд орсон байна. Эмээлт орчим байгуулагдах хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк төслийн үнэлгээ (0.888) мөн мэдэгдэхүйц өсч 6-р байрнаас 5-р байранд орсон. Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах төслийн үнэлгээ мөн мэдэгдэхүйц хэмжээгээр өсч жагсаалтын 13-р байрнаас 9-р байр хүртэл дээшлэв. Ерөнхийдөө зөвлөлдөөний дараагаар “Улаанбаатар хотын 9 дүүргийн нутаг дэвсгэрт хэд хэдэн хүн амын төвтэй болох” санааг маш ихээр дэмжсэн бөгөөд “замын хөдөлгөөний бөглөрөл ачааллыг бууруулах” (.728), “хотын төв орчмын хүн амыг бууруулах” (.758), “дотоод эдийн засгийг бэхжүүлэх” (.749, мэдэгдэхүйц өсөлт), “хотыг орчин үеийн шинжтэй болгон шинэчлэх” (.739), “илүү сайхан амьдрах орчныг бий болгох” (.807, мэдэгдэхүйц өсөлт) гэсэн зорилтуудыг биелүүлэхэд нэмэр болно гэж үзсэн байна. Зөвлөлдөөний дараагаар “аюултай ба хортой хог хаягдал гаргах болон хадгалах үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр компаниудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх ёстой” гэсэн санааг маш хүчтэй дэмжсэн байна. Үүний дэмжлэг эрс өсч 0.877-с 0.929 болсон байна. Үүнээс гадна “нэг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж компаниудыг нүүлгэн шилжүүлэн тодорхой цэгт төвлөрүүлэх” (0.775) мөн эдгээр компаниудад урамшуулал олгох (0.822 хүрч мэдэгдэхүйц өссөн) гэсэн санааг дэмжих үнэлгээ маш өндөр байна.

Төр хувийн хэвшлийн түншлэл: Эдгээр төслүүдийн хэд хэд нь төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүд юм. Зөвлөлдөөнд оролцогчид төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар хоёрдмол хандлагатай байсан бөгөөд “урт хугацааны төр хувийн хэвшлийн түншлэл нь төр болон хувийн хэвшлийн хооронд эрүүл бус харилцаа үүсгэдэг” (.627) ба “зарим компаниудад шударга бусаар давуу тал олгодог” (.674) гэсэн байна. Харин нөгөө талаар “Төр хувийн хэвшлийн түншлэл хот өөрөө гаргах боломжгүй санхүүжилтийн хөрөнгө оруулалтыг бий болгох боломж олгодог” (.718 хүрч зөвлөлдөөний дараагаар мэдэгхүйц өссөн) and мөн “төр хувийн хэвшлийн түншлэл эдийн засгийн өсөлтийг дэмжиж шинэ ажлын байр бий болгодог” (.830) гэж үзсэн байна. Зөвлөлдөөний дараагаар төр хувийн хэвшлийн түншлэлийн дэмжлэг ерөнхийдөө өссөн бөгөөд үүнийг дараах асуултанд хэрхэн хариулсанаас харах боломжтой: “Төр хувийн хэвшлийн түншлэл нь засгийн газар өөрөө гаргах боломжгүй санхүүжилтийг бий болгодог учраас ерөнхийдөө эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй гэж зарим хүмүүс үздэг бол эдгээр төслүүд хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлагад түлхүү чиглэсэн байдаг тул төр хувийн хэвшлийн түншлэл нь эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөөтэй гэж үздэг хүмүүс ч байдаг.” Зөвлөлдөөнд оролцогчдын үнэлгээ төр хувийн хэвшлийн түншлэлийн талд эхэлсэн бөгөөд (“эдийн засгийн хөгжилд сайн”) зөвлөлдөөний дараагаар энэ бодол улам баталгаажсан байна (0.448-аас 0.377 болсон, үүнд 0 үнэлгээ “эдийн засгийн хөгжилд сайн” харин 1 үнэлгээ нь “эдийн засгийн хөгжилд муу” гэсэн санааг илэрхийлнэ). Үүнээс гадна өөр асуултанд оролцогчид мөн хувийн хэвшлийн зах зээлд засгийн газрын хөндлөнгийн оролцоог дэмжсэн байна (0. 563-аас 0. 613 болсон, үүнд 0 үнэлгээ “засгийн газрын хөндлөнгийн оролцооны эсрэг” харин 1 үнэлгээ нь “засгийн газрын хөндлөнгийн оролцоог дэмжсэн” гэсэн санааг илэрхийлнэ).

Өр зээл ба татвар: Оролцогчдыг сонголт хийлгэхэд чиглэсэн хоёр асуулт өр зээл ба татварын талаарх ерөний чиг баримжааг харуулсан. Оролцогчдоос энэ хоёр байр суурийн алийг нь дэмжиж байгааг асуусан байна: “Зарим хүмүүс хот өр зээл тавьсан ч хотыг аль болох хурдан хөгжүүлэх ёстой гэж үздэг. Харин зарим хүмүүс хотын хөгжил удаашрах байсан ч өр зээлийг хязгаарлах нь зүйтэй гэж үздэг.” Оролцогчид эхлээд өр зээлийг нэмэгдүүлэхийг хүчтэй эсэргүүцэж байсан ч зөвлөлдөөний дараагаар дундыг баримтлах тийш хандсан байна (.845 байсан бол .792 болж мэдэгдэхүйц буурсан байна). Татварын хувьд оролцогчдоос мөн аль нэг байр суурийг сонгох асуулт асуусан: “Зарим хүмүүс татвар нэмэгдсэн ч зарим нэн чухал шаардлагатай дэд бүтэц болон хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй гэж үздэг. Харин зарим хүмүүс зарим төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлэх боломжгүй ч татвар нэмэгдүүлэх ёсгүй гэж үздэг.” Зөвлөлдөөний дараагаар оролцогчид хөгжлийг удаашруулсан ч татварын нэмэгдлийн эсрэг үзэл бодолтой хэвээрээ байна (0.682, мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй).

Шинэ хөгжил, бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх зорилготой татварын нэмэгдлийн эсрэг байр суурь нь Метро болон Экологийн коридор төслүүдийн үнэлгээ хэрхэн өөрчлөгдсөнийг тайлбарлах боломжтой юм. Метро төслийн үнэлгээ эрс буурч 0.742-с 0.670 хүрсэн бөгөөд жагсаалтанд 11-р байрнаас 13-р байр болж унасан байна. Экологийн коридор төслийн үнэлгээ мөн эрс буурч 0. 795-с 0. 644 хүрсэн бөгөөд жагсаалтанд 7-р байрнаас 14-р байр болж унасан байна. Метро төсөл нь маш үнэтэй бөгөөд их хэмжээний өр зээл шаардах юм. Харин экологийн коридор төсөл нь өөрийн гэсэн орлогын эх үүсвэргүй, ашиг олоход чиглээгүй тул бусад төслүүдээс ялгаатай юм. Нэмэлт тоон болон

чанарын дүн шинжилгээнүүд эдгээр төслүүдийн дэмжлэг яагаад их хэмжээгээр бүүрсаныг илүү дэлгэрэнгүй тайлбарлах болно. Түүнээс гадна хэлэлцүүлгийн бичлэг болон хурлын протоколууд зарим төслүүдийн дэмжлэгийг нэмэгдүүлэхэд шаардлагатай, иргэдийн санааг зовоож, ач холбогдол өгч буй зүйлсийн талаар мэдээлэл өгч магадгүй.

Мэдлэг. Санал асуулга ойлголт мэдлэгийн түвшнийг тогтооход чиглэсэн 7 тодорхой асуултыг агуулсан. Мэдлэгийн индекс буюу мэдлэгийн түвшин нь бодлогын хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг тайлбарлах боломжтой хувьсагч хэмжигдэхүүн байж болно. Зөвлөлдөөний дараагаар зөв хариулсан байдлын түвшин бага зэргийн хэдий ч маш чухал хэмжээгээр өссөн байна (3.8 оноогоор, статистикийн мэдэгдэхүйц ялгааны үзүүлэлт = 0.007). Эдгээр асуултуудад Улаанбаатар хотын айл өрхүүдийн орон сууцанд оршин суудаг хувь (зөв хариулсан оролцогчдын тоо 47 хувиас 59 хувь хүрсэн) болон газар булдаг хог хаягдлын хэмжээ (зөв хариулсан оролцогчдын тоо 23 хувиас 35 хувь хүрч өссөн) байсан. Зарим асуултууд харьцангуй хүнд хэцүү байсан тул оролцогчдыг төөрөлдүүлсэн байх магадлалтай юм. Хавсралт Д мэдлэгийн түвшний асуултуудын үр дүнг агуулна.

Үр нөлөөтэй байдал ба харилцан хүндэтгэл. Зөвлөлдөөн эхлэхэд оролцогчдын үр нөлөөтэй байдал буюу өөрчлөлт гаргахад нөлөөлж чадна гэсэн итгэл бага байсан. Тэд олон нийтийн асуудлуудыг хүнд хэцүү түвэгтэй гэж үзэж байсан бөгөөд зөвлөлдөөний өмнө ч дараа ч “над шиг хүмүүс төр засгийн газар хийх зүйл гаргах шийдвэрт нөлөөлж чадахгүй” гэсэн бодолтой байна (.808, мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй). Харин “төрийн албан хаагчид над шиг хүмүүс ямар бодолтой байгааг тоодог анхаардаг” гэдэгтэй санал нийлэх оролцогчдын тоо эрс нэмэгдсэн байна (санал нийлэхгүй байна .398 байсан бол санал нийлж байна .544 болсон байна). Энэхүү өөрчлөлт нь төслийн хэмжээнд хамгийн чухал өөрчлөлтүүдийн нэг байсан бөгөөд статистикийн мэдэгдэхүйц ялгааны үзүүлэлтийн хувьд ч хүчтэй байв (0.000 түвшинд). “Маш хүчтэй санал нийлэхгүй” гэж үздэг хүмүүсийн талаар оролцогчдоос асуухад зөвлөлдөөний дараагаар харилцан хүндэтгэлтэйгээр хандах байдал ихээр нэмэгдсэн байна. Өөртэй нь санал нийлэхгүй байгаа хүмүүс “ингэж бодох сайн шалтгаан байгаа; нөгөө талаас нь харахад сайн талууд ч байгаа.” гэж үзэх оролцогчдын тоо мөн нэмэгдэж энэ үзүүлэлт .654 байсан бол .739 хүрсэн байна (статистикийн мэдэгдэхүйц ялгааны үзүүлэлт .000 түвшинд). Мөн “тэд өөрсдийн эрх ашгийг бодож хамгаалж байгаа” (.694-с .621) ба “эдгээр хүмүүстэй харилцан тохиролцоонд хүрэхгүй” (.656-с .601 буюу огцом буурсан) гэж үзэх оролцогчдын үзүүлэлт эрс буурсан байна. Хамтран ажиллахын хувьд “хоёр талаасаа хамтран нэг шийдэл олохын тулд буулт хийхэд би бэлэн байна” гэж үзэх оролцогчдын бодол эрс нэмэгдсэн байна (.675-с .726).

Арга хэмжээний үнэлгээ. Эцсийн санал асуулгад оролцогчдоос зөвлөлдөөний арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болгоныг үнэлэхийг асуусан. Оролцогчдын 94.3 хувь нь “нийт үйл явцыг бүхэлд нь” “ач холбогдолтой буюу хэрэгтэй” гэж үзсэн байна. 95 хувь нь жижиг бүлгийн хэлэлцүүлэгт оролцсоныг “ач холбогдолтой буюу хэрэгтэй” гэж үзсэн байна. 93.4 хувь нь жижиг бүлгийн хэлэлцүүлгээс гадуур бусад гишүүд төлөөлөгчидтэй уулзаж ярихыг “ач холбогдолтой буюу хэрэгтэй” гэж үзсэн бол 95 хувь нь нэгдсэн хэлэлцүүлгийн талаар ижил бодолтой байна. Модераторуудын үнэлгээний хувьд оролцогчдын 98.1 хувь нь “манай бүлгийн модератор бүлгийн бүх гишүүдэд хэлэлцүүлэгт оролцох боломж олгосон” гэдэгтэй санал нийлсэн байна. 97.5 хувь нь “манай бүлгийн гишүүд хэлэлцүүлэгт харьцангуй тэгш байдлаар оролцсон” гэж үзсэн бол 97.5 хувь нь “манай

бүлгийн модератор бүлгийн гишүүдэд өөрийн үзэл бодлоо тулгаж ямар нэгэн байдлаар нөлөөлөх гэж оролдсон” гэдэгтэй маш хүчтэйгээр санал нийлэхгүй байна гэж хариулсан байнаⁱⁱ. 95.6 хувь нь “би өөрөөсөө их ялгаатай хүмүүсээс маш их юм сурлаа – тэдгээрийн талаар болон тэдгээрийн аж амьдралын талаар” гэдэгтэй санал нийлсэн байна.

Үйл явцын төгсгөлд оролцогчдын 84.8 хувь нь урьдчилан тараасан товч мэдээлэл өгөх материалуудын хагас буюу түүнээс дээш хувьтай нь уншиж танилцсан гэсэн бөгөөд 72.8 хувь нь энэхүү материалыг “дундыг баримталсан буюу тэнцвэртэй” болон “ерөнхийдөө дийлэнх нь дундыг баримталсан буюу тэнцвэртэй” гэж үзсэн байна. Үнэлгээний бүх асуултуудыг Хавсралт E-ээс харна уу.

Хавсралт А: Зөвлөх хороо

Зөвлөх хорооны дарга С. Бат-Үүл (Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч)

Зөвлөх хороог хамтран даргалагч Г. Занданшатар (Стэнфордын Их сургуулийн Зөвлөлдөх ардчиллын хүрээлэнгийн ахлах зөвлөх)

Ерөнхий сайд асан Д. Содном

Гадаад хэргийн сайд асан Ц.Гомбосүрэн

Хас банкны ТУЗ-ийн дарга Ч.Ганболд

Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн Философийн ухааны доктор, профессор Б.Даш-Ёндон

Гандантэгчинлэн хийдийн Хамба лам Д.Чойжамц

Монголын Урлагийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Т.Ариунаа

MCS группын Ерөнхийлөгч Ж.Од

Нийтлэлч Б.Батбаяр

Алтан тариа ХК-ийн захирал П.Цэнгүүн

Монфэмнэт Үндэсний сүлжээ ТББ-ын ахлах зөвлөх Д.Сүхжаргалмаа

МУИС-ийн Ректор Р.Бат-Эрдэнэ

Хавсралт Б: Бодол санаанд гарсан өөрчлөлт

Тэмдэглэл: Танилцуулж буй судалгааны үр дүн нь өмнөх болон дараахь санал асуулгын дундаж болон статистик ач холбогдлын түвшний ялгааг харуулсан өмнөх болон дараахь санал асуулгын дунджаар илэрхийлэгдсэн болно. Ач холбогдлын түвшин нь 0.01-ээс бага байвал “****”, 0.05-аас бага байвал “***”, 0.10-аас бага байвал “**” гэж тэмдэглэсэн болно. Бүх хэмжээсийг 0-1 гэсэн хэмжээст шилжүүлсэн, өөрөөр хэлбэл 0-10 гэсэн хэмжээсийг 1 нь хамгийн өндөр байх 0-1 гэсэн хэмжээст шилжүүлсэн болно.

1. 0 нь “огт хэрэггүй”, 10 нь “хамгийн их хэрэгтэй”, 5 нь яг дунд нь байх 0-10 гэсэн хэмжээсийн хувьд та дараах зүйлсийг хэр чухал хэрэгтэй гэдгийг хэрхэн үнэлэх вэ?

Асуулт 1	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2-Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
а. Улаанбаатар метро <i>Ихэвчлэн газар доогуур явах, Толгойтоос Амгалан өртөө хүртэл явах Энхтайваны өргөн чөлөөний нийт 14 зогсоолтой Метроны шугам.</i>	.742	.670	-.071	.003***
б. Туул голын усан сангийн цогцолбор <i>Туул голын дагуу ус цэвэршүүлэх байгууламж байгуулж, түүнтэй холбоотой дэд бүтцийг бий болгох юм.</i>	.897	.773	-.123	.000***
с. УБ-Налайх хурдны зам <i>Хотын төвөөр орохгүйгээр явж өнгөрөх Туул голын дагуух хурдны зам.</i>	.738	.735	-.003	.912
д. Эмээлт дэх хөнгөн үйлдвэрийн парк <i>Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатар хотын төвөөс Хан-Уул дүүргийн 13-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд байрлах шинээр баригдсан, орчин үеийн байгууламж руу нүүлгэн шилжүүлнэ.</i>	.840	.880	.040	.018**
е. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк <i>Налайх дүүргийн 3-р хороонд байрлах барилгын материал үйлдвэрлэдэг компаниудад зориулсан аж үйлдвэрийн шинэ парк.</i>	.759	.887	.127	.000***
ф. Одоогийн хогийн цэг дээр барих Эко парк болон хог хаягдал дахин боловсруулах 2 байгууламж <i>Хоёр гол хогийн цэгтэй холбоотой цогцолборын дэргэд хог хаягдал дахин боловсруулах компаниуд болон дахин боловсруулсан материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудтай болно.</i>	.921	.923	.002	.862

Асуулт 1	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2-Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
<p>g. Улаанбаатар хотын зүүн хэсэгт байрлах ачаа тээвэр логистикийн төв</p> <p><i>Улаанбаатар хотод түгээх ачаа барааг галт тэрэгнээс ачааны машинд шилжүүлэхэд зориулсан логистикийн төвд шаардлагатай дэд бүтцийг барьж байгуулах.</i></p>	.705	.759	.054	.005***
<p>h. Орон сууцны барилгуудын дулаалгыг сайжруулах</p> <p><i>Улаанбаатар хотын 1,077 угсармал орон сууцны дулаалгыг оршин суугчидтай хамтран сайжруулах.</i></p>	.874	.835	-.039	.018**
<p>i. Бага тойруугийн хуучин барилгуудыг нурааж, шинээр барилга барих</p> <p><i>Зарим хуучин, аюултай барилгуудыг буулгаж, оронд нь шинэ бүтээн байгуулалт хийх замаар Улаанбаатар хотын төвийг шинэчлэх.</i></p>	.787	.793	.006	.753
<p>j. Монгол Наадам цогцолборын барилга – Заалны болон гадна талбайн спортын байгууламжууд</p> <p><i>Наадам болон бусад спортын арга хэмжээг зохион байгуулах цэнгэлдэх хүрээлэн болон жуулчдад зориулсан барилга, байгууламжуудыг барих.</i></p>	.760	.741	-.020	.406
<p>к. Эко коридор</p> <p><i>Уугуул ан амьтны төрөл зүйлийн уламжлалт нүүдлийн замыг хадгалах зорилгоор ойжуулалт болон дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх.</i></p>	.795	.644	-.151	.000***
<p>i. Туул, Сэлбэ голыг хамгаалах</p> <p><i>Ус боловсруулах технологийн туршилт, жижиг далан, хаалт, ус судлалын станц, голын урсацыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа, түүнчлэн голын дагуух еөрнхий орчинг сайжруулах тохижилтын төсөлд хөрөнгө оруулалт хийх.</i></p>	.954	.936	-.018	.091*
<p>м. УБ - Хийн төсөл</p> <p><i>Улаанбаатар хотын айл өрхийн хэрэгцээнд зориулан хийг хадгалах, түгээх дэд бүтцэд хөрөнгө оруулах.</i></p>	.664	.689	.025	.301
<p>п. Цэцэрлэг сургуулиудын халаалтыг сайжруулах</p> <p><i>42 сургууль, 50 цэцэрлэгийн дулаалгыг сайжруулах, мөн халаалтын технологи, системийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийх.</i></p>	.942	.945	.006	.527

1. 0-10 хүртэлх хэмжээсний хувьд 0 нь “огт ач холбогдолгүй”, 10 нь “хамгийн их ач холбогдолтой”, 5 нь яг дунд нь гэсэн оноо бөгөөд та дараах зорилго нэг бүр нь төрийн бодлоготой хэр уялдаж байгааг хэрхэн үнэлэх вэ? 0 нь “огт ач холбогдолгүй”, 10 нь “маш их ач холбогдолтой”, 5 нь яг дунд нь байхаар 0-10 хүртэлх хэмжээсээр үнэлнэ үү.

Асуулт 2	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2-Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
a. Цэвэр эрчим хүчээр хангаж, эрчим хүчний хэрэглээг бууруулах.	.879	.891	.012	.377
b. Үр ашигтай тээврийн сүлжээг бий болгох.	.830	.814	-.015	.333
c. Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах.	.939	.943	.003	.733
d. Олон нийтийн аюулгүй байдал, гамшгийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх.	.892	.896	.004	.756
e. Байшин барилгуудыг шинэчлэх.	.770	.822	.052	.007***
f. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих.	.957	.945	-.012	.199
g. Монгол соёлыг сурталчлах.	.930	.903	-.027	.020**
h. Байгаль, ан амьтдыг хамгаалах.	.935	.919	-.016	.146
i. Усан хангамжийг сайжруулах.	.953	.963	.010	.255
j. Шаардлага хангасан орон сууц барих.	.904	.926	.022	.085*
k. Амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх байгууламж, зай талбайг сайжруулах.	.866	.856	-.010	.501
l. Эдийн засгийг хөгжүүлэх.	.944	.922	-.022	.036**
m. Агаарын бохирдлыг бууруулах.	.964	.958	-.007	.481
n. Хөрсний бохирдлыг бууруулах.	.942	.943	.000	.977
o. Усны бохирдлыг бууруулах.	.966	.959	-.008	.361

(1=бусад хүмүүс)	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2-Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
Асуулт 3: Зарим хүмүүс хүрээлэн буй орчинд муу нөлөөтэй байсан хэдий ч эрчим хүч аль болох хямд байх ёстой гэж үздэг. Нөгөө хэсэг хүмүүс нь эрчим хүч үнэтэй байсан ч бид хүрээлэн буй орчноо хадгалж үлдэх ёстой гэж үздэг.	.735	.779	.045	.058*

(1=бусад хүмүүс)	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
Асуулт 4: Зарим хүмүүс хотын хуучны дурсгалт газрууд нь алга болсон ч хамаагүй хот аль болох түргэн шинэчлэгдэх ёстой гэж үздэг. Нөгөө хэсэг хүмүүс нь өөрчлөлт шинэчлэл удаан хийгдсэн ч хамаагүй бид хотын хуучны дурсгалт хэсгүүдийг хадгалж үлдэх нь зүйтэй гэж үздэг.	.813	.801	-.012	.611
Асуулт 5. Зарим хүмүүс маш их өрөнд орсон ч хамаагүй хотыг аль болох түргэн хөгжүүлэх ёстой гэж үздэг. Нөгөө хэсэг хүмүүс нь хотын хөгжил удааширсан ч хамаагүй хот өр зээлээ хязгаарлах ёстой гэж үздэг.	.845	.792	-.053	.022**
Асуулт 6. Зарим хүмүүс хуучны орон сууц олон байгаа хэдий ч тэдгээр барилгуудаа шинэчлэх нь зүйтэй гэж үздэг. Нөгөө хэсэг хүмүүс нь цөөн хүн орон байртай болсон ч хамаагүй шинэ орон байр барих нь зүйтэй гэж үздэг.	.568	.593	.025	.403
Асуулт 7. Зарим хүмүүс дэд бүтэц болон хөгжилтэй холбоотой чухал ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэхэд Улаанбаатар хотын татварыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үздэг. Нөгөө хэсэг хүмүүс нь зарим төслүүд хэрэгжихгүй байсан ч хамаагүй татварыг нэмэгдүүлэхгүй байх нь зүйтэй гэж үздэг.	.670	.682	.012	.655

8. Улаанбаатар хотын 9 дүүрэгт дараах нөхцлийг хангасан хүн амын хэд хэдэн төвлөрлийн бүс бий болгоно гэдэгтэй та санал хэр нийлж байна вэ? (санал нийлж байна=1, санал нийлэхгүй байна=0)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
a. Хүн амын хэт нягтралыг бууруулна.	.699	.728	.030	.163
b. Хотын төвийн бохирдлыг бууруулна.	.729	.758	.029	.150
c. Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлнэ.	.707	.749	.042	.030**
d. Хотын соёлыг өөрчилнө.	.697	.700	.003	.879
e. Хотыг шинэчилнэ.	.711	.736	.025	.186

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
f. Илүү сайхан амьдрах орчныг бий болгоно.	.764	.807	.043	.023**

9. Дараах зүйлс биелэх боломжтой эсвэл боломжгүй болохыг тодорхойлно уу. 0 нь “огт боломжгүй”, 10 нь “бүрэн боломжтой”, харин “5” нь “яг дунд нь” байх дээр 0-10 хүртэлх онооны хэмжээсээр үнэлнэ үү.

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
Орон сууцны тоог нэмэгдүүлэх нь бохирдлыг бууруулна.	.732	.803	.071	.001***
Шинэ дэд бүтцийг барьж байгуулах нь эдийн засгийн хөгжлийг хурдасгана.	.787	.832	.044	.022**
Дагуул хотыг хөгжүүлснээр хүн амын нягтралыг сааруулна.	.878	.898	.020	.183

10. Дараах саналуудыг та хэр дэмжиж эсвэл эсэргүүцэж байна вэ? (0=эсэргүүцэж байна, 1=дэмжиж байна)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
a. Аюултай хог хаягдал үйлдвэрлэдэг эсвэл хадгалдаг компаниудыг хотын төвөөс нүүлгэх шаардлагатай .	.877	.929	.052	.006***
b. Аюултай хог хаягдал үйлдвэрлэдэг эсвэл хадгалдаг компаниудыг урамшуулах хэрэгтэй, гэхдээ хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.	.197	.200	.002	.918
c. Засгийн газраас энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хотын тодорхой хэсэгт байршуулахыг шаардах хэрэгтэй.	.765	.775	.010	.695
d. Засгийн газраас ийм салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудыг хотын тодорхой хэсэг рүү нүүхэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.	.770	.822	.052	.019**

11. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх дараах зүйлстэй та хэр санал нийлж байна вэ? (санал нийлж байна=0, санал нийлэхгүй байна=1)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
а. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг урт хугацаанд ашиглах нь төр болон хувийн хэвшлийн хооронд эрүүл бус түншлэлийг бий болгодог.	.639	.627	-.010	.691
б. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг урт хугацаанд ашиглах нь зарим компаниудад шударга бус давуу байдлыг олгодог	.677	.674	-.003	.892
с. Төр ба хувийн хэвшлийн түншлэл нь хотын захиргаанд өөрсдийн хөрөнгөөр хийж дийлэхгүй хөрөнгө оруулалтыг хийх боломжийг олгодог.	.656	.718	.062	.015**
д. Төр ба хувийн хэвшлийн түншлэл нь өсөлтийг дэмжиж, ажлын байрыг бий болгодог.	.801	.830	.028	.179

(1=бусад хүмүүс)	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдол
Асуулт 12. Зарим хүмүүс төр хувийн хэвшлийн түншлэл (ТХТ) нь төрөөс гаргаж чадахгүй байгаа санхүүжилтийг бий болгодог учраас ТХТ нь хөгжилд ерөнхийдөө сайн нөлөөтэй гэж үздэг. Нөгөө хэсэг хүмүүс төслүүд нь хувийн хэвшлийн хэрэгцээг л хангадаг учраас ТХТ нь ерөнхийдөө хөгжилд муу нөлөөтэй гэж үздэг.	.448	.377	-.071	.005***

(0= огт итгэхгүй байна, 1= бүрэн итгэж байна)	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
Асуулт 13. Та Улаанбаатар хотын захиргаа зөв зүйл хийж байгаа эсэхийг 0 нь “огт итгэхгүй байна”, 10 нь “бүрэн итгэж байна”, 5 нь “яг дунд нь” гэсэн утгаар 0-10 хүртэлх хэмжээсээр үнэлнэ үү?	.595	.797	.202	.000***

(0=хувийн хэвшил, зах зээлийн үйл ажиллагаанд огт оролцож болохгүй, 1=бүрэн оролцох ёстой)	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин

Асуулт 14. Та Монгол Улсын засгийн газар хувийн хэвшил, зах зээлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ёстой эсэх дээр саналаа хэлнэ үү. 0 нь “хувийн хэвшил, зах зээлийн үйл ажиллагаанд огт оролцож болохгүй”, 10 нь “бүрэн оролцох ёстой”, 5 нь “яг дунд нь” гэсэн утгаар 0-10 хүртэлх хэмжээсээр санал бодлоо хэлнэ үү.	.553	.613	.059	.014**
--	------	------	------	--------

15. Хүмүүст өөрсдөд нь эсвэл нийгэмд чухал эсвэл чухал биш гэж үздэг зарим зүйлсийг доор жагсаалаа. Та дараах зүйлс нь таны хувьд чухал эсвэл чухал биш гэдгийг 0 нь “огт чухал биш”, 10 нь “маш чухал”, 5 “яг дунд нь” байх 0-10 хүртэлх хэмжээсээр үнэлнэ үү? (1= маш чухал)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
a. Хүн бүр эрх тэгш боломжоор хангагдах.	.935	.939	.008	.756
b. Хүмүүс болон компаниудыг эдийн засгийн хувьд чөлөөтэй өрсөлдөх боломжоор хангах.	.874	.900	.026	.089*
c. Хаана амьдрахаа сонгох боломжтой байх.	.926	.952	.026	.033**
d. Хэн ч хоол хүнс эсвэл орон байргүй байна гэж санаа зовохгүй байх.	.894	.891	-.003	.849
e. Боломжийн хэрээр их мөнгө олох.	.886	.882	-.004	.812
f. Олсон мөнгөө яаж зарцуулахаа яг өөрөө шийддэг байх.	.939	.949	.011	.303
g. Төр засаг хүмүүсийн хүсч буй зүйлийг хийдэг байх.	.870	.915	.044	.004***
h. Баян ядуугийн ялгааг багасгах.	.905	.922	.017	.231
i. Эдийн засгийн хөгжлийг дэмжих.	.941	.965	.024	.011***
j. Аюулгүй нийгэмтэй байх.	.970	.979	.009	.272
k. Хүн бүр цэвэр агаар, устай орчинд амьдрах.	.989	.990	.001	.730

16. Та дараах асуудлуудтай хэр зэрэг санал нийлж эсвэл санал нийлэхгүй байна вэ?
(санал нийлж байна=1)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
a. Бидэн шиг хүмүүс юу бодож байгаа тал дээр төрийн албан хаагчид их анхаардаг.	.398	.544	.146	.000***
b. Төрийн бодлогын ихэнх асуудлууд бидэн шиг хүмүүс ойлгохооргүй нь ихээхэн төвөгтэй байдаг.	.620	.646	.025	.290

с. Бидэн шиг хүмүүст төрийн хийж буй зүйлсд хэлэх үг байдаггүй.	.572	.556	-.016	.581
d. Би улс төрийн талаарх өөрийн гэсэн бодол санаатай, миний үзэл бодлыг сонсууштай, үнэ цэнэтэй.	.800	.806	.006	.789

17. Бидний танаас асууж буй зүйлс дээр тантай огт санал нийлэхгүй хүмүүс мэдээж байгаа. Та тэдгээр хүмүүсийн талаарх дараах дүгнэлтүүдтэй та хэр санал нийлж эсвэл нийлэхгүй байна вэ? (санал нийлэхгүй байна=0, санал нийлж байна=1)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдлын түвшин
a. Тэд хангалттай сайн мэдэхгүй.	.600	.625	.025	.255
b. Тэд улс төржсөн бөгөөд намын удирдлагаа л дагадаг.	.665	.648	-.017	.493
с. Зарим зүйлс нь үнэн биш гэдэгт тэд итгэлтэй байгаа.	.666	.680	.014	.498
d. Тэд сайн бодохгүй байна.	.631	.632	.001	.956
e. Тэдэнд ингэж бодох сайн шалтгаан байгаа; нөгөө талаас нь харахад сайн талууд ч байгаа.	.654	.739	.085	.000***
f. Тэд өөрсдийн эрх ашгийг л илүүд үзэж байна	.694	.621	-.072	.002***

18. Бидний танаас асууж буй зүйлс дээр тантай огт санал нийлэхгүй хүмүүс мэдээж байгаа. Тэдгээр хүмүүстэй холбоотой дараах асуудлуудтай та хэр санал нийлж эсвэл санал нийлэхгүй байна вэ? (санал нийлж байна=1, санал нийлэхгүй байна=0)

	Хугацаа 1	Хугацаа 2	Хугацаа 2- Хугацаа 1	Ач холбогдол
a. Минийхээс өөр байсан ч би тэдний үзэл бодлыг хүндэтгэж байна.	.775	.748	.028	.158
b. Тэдэнтэй зөвшилцөхөд хэцүү.	.656	.601	-.055	.016**
с. Би буулт хийж, дундаасаа нэг шийдэл гаргахад бэлэн.	.675	.726	.051	.039**

Хавсралт В: Хүн ам зүйн төлөөлөх чадвар

Тэмдэглэл: Эдгээр үр дүн нь Зөвлөлдөх санал асуулгын бүх үйл явцад хамрагдсан оролцогчид болон арга хэмжээнд оролцолгүй зөвхөн зөвлөлдөөний өмнөх санал асуулгад хамрагдсан оролцогчдыг харьцуулсан юм. Зөвлөлдөх санал асуулгын хэлэлцүүлэгт оролцогчид болон оролцогч бус иргэдийн хооронд ялгаа байгаа эсэхийг статистик ач холбогдлын түвшингээр нь харуулав.

	Оролцогч иргэд /ОИ/ (Тоо=317)	Оролцогч бус иргэд /ОБИ/ (Тоо=1185)	Ач холбогдлын түвшин
Хүйс	(%)	(%)	
Эрэгтэй	48.3	50.5	Ач холбогдолгүй
Эмэгтэй	51.7	49.5	
Боловсрол			Ач холбогдолгүй
Магистр/ Доктор эсвэл түүнээс дээш	4.7	5.1	
Баклавр эсвэл их сургуулийн диплом	28.1	30.3	
Бүрэн дунд боловсрол	44.8	46.6	
Мэргэжлийн боловсрол	10.4	6.8	
Бүрэн бус дунд боловсрол	10.1	9.4	
Бага боловсрол	1.3	1.5	
Боловсролгүй	0.6	0.3	
Нас (жилээр)	40.8	40.3	Ач холбогдолгүй
Одоогийн эрхэлж буй ажил?			Ач холбогдолгүй
Төрийн болон төсвийн байгууллага	7.6	8.9	

	Оролцогч иргэд /ОИ/ (Тоо=317)	Оролцогч бус иргэд /ОБИ/ (Тоо=1185)	Ач холбогдлын түвшин
Төрийн бус байгууллага	0.3	0.8	
Хувийн хэвшил	21.8	21.3	
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	23.0	21.1	
Малчин	0.3	0.3	
Оюутан	6.9	8.5	
Ажилгүй	26.5	23.1	
Бусад	13.6	16.1	
Гэрлэлтийн байдал			Ач холбогдолгүй
Ганц бие	19.6	22.5	
Гэрлэсэн	72.9	67.7	
Тусдаа амьдардаг/Салсан/Бэлэвсэн	7.6	9.8	
18-аас доош настай хүүхдийн тоо	1.4	1.3	Ач холбогдолгүй
Өрхийн сарын орлого (төгрөгөөр)			Ач холбогдолгүй
200,000 хүртэл	10.2	7.8	
200,001 - 500,000 хооронд	31.4	34.7	
500,001 - 1,000,000 хооронд	39.1	38.1	
1,000,001 - 1,500,000 хооронд	12.7	13.0	
1,500,001 - 2,000,000 хооронд	4.8	3.9	
2,000,001 дээш	1.9	2.6	
Амьдарч буй орон байрны хэлбэр			
Монгол гэр	33.4	26.8	.020

	Оролцогч иргэд /ОИ/ (Тоо=317)	Оролцогч бус иргэд /ОБИ/ (Тоо=1185)	Ач холбогдлын түвшин
Хашаа байшин	24.9	28.5	Ач холбогдолгүй
Орон сууц	37.9	42.6	.127
Нийтийн байр	3.8	1.6	.015
Хувийн байшин	0.0	0.5	Ач холбогдолгүй
Оршин суугаа хугацаа			0.001
6 сараас 1 жил	18.9	15.5	
1-2 жил	14.8	10.1	
3-5 жил	18.6	17.7	
6-10 жил	19.2	17.6	
11 жил эсвэл түүнээс дээш	28.4	39.0	

Хавсралт Г: Бодлоготой холбоотой хувилбаруудын талаарх хандлагын байдал

Тэмдэглэл: Эдгээр үр дүн нь Зөвлөлдөх санал асуулгын бүх үйл явцад хамрагдсан оролцогчид болон арга хэмжээнд оролцолгүй зөвхөн зөвлөлдөөний өмнөх санал асуулгад хамрагдсан оролцогчдыг харьцуулсан юм. Зөвлөлдөх санал асуулгын хэлэлцүүлэгт оролцогчид болон оролцогч бус иргэдийн хооронд ялгаа байгаа эсэхийг статистик ач холбогдлын түвшингээр нь харуулав. Ач холбогдлын түвшин нь 0.01-ээс бага байвал “***”, 0.05-аас бага байвал “**”, 0.10-аас бага байвал “*” гэж тэмдэглэсэн болно.

1. 0 нь “огт хэрэггүй”, 10 нь “хамгийн их хэрэгтэй”, 5 нь яг дунд нь байх 0-10 гэсэн хэмжээсийн хувьд та дараах зүйлсийг хэр чухал гэдгийг хэрхэн үнэлэх вэ?

	Оролцогч иргэд /ОИ/ (Тоо=317)	Оролцогч бус иргэд /ОБИ/ (Тоо=1185)	ОИ - ОБИ	Ач холбогдлын түвшин
a. Улаанбаатар метро	.742	.739	.002	.902
b. Туул голын усан сангийн цогцолбор	.897	.865	.031	.028**
c. Туул хурдны зам	.738	.741	-.003	.884
d. Эмээлт дэх хөнгөн үйлдвэрийн парк	.840	.810	.030	.067*
e. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк.	.759	.732	.028	.108*
f. Одоогийн хогийн цэг дээр барих Эко парк болон хог хаягдал дахин боловсруулах 2 байгууламж.	.921	.915	.006	.553
g. Улаанбаатар хотын зүүн хэсэгт байрлах ачаа тээвэр логистикийн төв	.704	.694	.011	.527
h. Орон сууцны барилгуудын дулаалгыг сайжруулах.	.874	.849	.025	.098*
i. Бага тойруугийн хуучин барилгуудыг нурааж, шинээр барилга барих.	.788	.770	.018	.312
j. Монгол Наадам цогцолборын барилга – Заалны болон гадна талбайн спортын байгууламжууд	.760	.689	.071	.000***
k. Эко коридор	.796	.769	.027	.133
l. Туул, Сэлбэ голыг хамгаалах	.954	.952	.002	.857
m. УБ - Хийн төсөл	.664	.659	.005	.785

	Оролцогч иргэд /ОИ/ (Тоо=317)	Оролцогч бус иргэд /ОБИ/ (Тоо=1185)	ОИ - ОБИ	Ач холбогдлын түвшин
n. Цэцэрлэг сургуулиудын халаалтыг сайжруулах	.942	.930	.012	.188

Хавсралт Д: Мэдлэгⁱⁱⁱ

Асуулт (Зөв %)	Өмнөх	Дараах	Дараах-Өмнөх	Ач холбогдлын түвшин
Улаанбаатар хотын айл өрхийн хэдэн хувь нь 2010 онд орон сууцанд амьдарч байсан бэ? (Зөв хариулт: 40%)	46.7	59.0	+12.3	.001
Улаанбаатар хот ундны усны эх үүсвэрээ хаанаас хангадаг вэ? (Зөв хариулт: Газар доорх уст давхарга ба голын ус)	25.9	24.3	-1.6	.647
Өнгөрсөн жил ойролцоогоор хэр их хог хаягдлыг газарт булсан бэ? (Зөв хариулт: 1.5 сая тонн)	23.3	35.0	+11.7	.001
Дараахаас аль нь ҮНЭН бэ? (Зөв хариулт: Шингэн хийн түлшийг 100% импортлодог)	25.9	27.4	+1.5	.630
Улаанбаатар хотын агаарыг бохирдуулагч гол 3 эх үүсвэр нь юу вэ? (Зөв хариулт: Дулаан ба цахилгаан станцууд, тээврийн хэрэгсэл, гэр хороолол; Дулаан ба цахилгаан станцууд, гэр хороолол, шороон замын тоос)	89.3	87.1	-2.2	.379
Хотын 2014 оны төсвийн зардлын хичнээн хувийг өр төлөхөд зарцуулсан бэ? (Зөв хариулт: 0)	3.2	4.1	+0.9	.533
Мэдлэгийн Индекс (6 асуулт)	35.7	39.5	+3.8	.007

Хавсралт Е: Үнэлгээ

Дараах зүйлүүд асуудлуудын талаар та өөрийн байр сууриа тодруулахад хэр ач холбогдолтой байсан бэ? 0 нь “цаг үрсэн хэрэг”, 10 нь “маш их ач холбогдолтой”, 5 нь “яг дунд нь” байх 0-10 хүртэлх оноогоор үнэлнэ үү?	Ач холбогдол %
a. Үйл явц бүхэлдээ	94.3
b. Жижиг бүлгийн хэлэлцүүлэгт оролцох	95.0
c. Бүлгийн хэлэлцүүлгээс гадна бусад төлөөлөгчидтэй уулзаж, ярилцах	93.4
d. Нэгдсэн хуралдаан	95.0
	Санал нийлж байна %
Та дараах мэдэгдэлтэй хэр санал нийлж эсвэл нийлэхгүй байна вэ?	
a. Манай бүлгийн хэлэлцүүлгийн удирдагч хүн бүрийг хэлэлцүүлэгт оролцох боломжийг бүрдүүлж өгсөн.	98.1
b. Манай бүлгийн гишүүд хэлэлцүүлэгт харьцангуй эрх тэгш оролцсон.	97.5
c. Манай бүлгийн хэлэлцүүлгийн удирдагч заримдаа өөрийн үзэл бодлоо тулгахыг оролдож байсан.	90.9
d. Манай бүлгийн хэлэлцүүлгийн удирдагч эсрэг байр суурийг мөн авч үзэхийг хичээж байсан.	22.1
e. Бүлгийн хэлэлцүүлгээр чухал асуудлуудыг ярилцаж чадсан.	95.6
f. Надаас тэс ондоо хүмүүсээс би их зүйлийг олж сурсан –тэд хэн болох, мөн тэдний амьдралын талаар.	95.6
g. Цөөн хэдэн гишүүн хэлэлцүүлэгт голлон оролцож байсан.	46.1

h. Манай бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид нэг нэгнийхээ үзэл бодлыг хүндэтгэж байсан.	99.1
Өнөөдрийн арга хэмжээнээс өмнө товч танилцуулга материалыг уншихад та хичнээн их цагийг зарцуулсан бэ?	
Огт уншаагүй	2.5
Хагас цаг орчим	12.9
Цаг орчим	24.3
Цаг хагас орчим	7.3
Хоёр цаг орчим	18.0
Хоёроос дээш цаг	35.0
Хэлэлцүүлэгүүд эхлэхээс өмнө өгөгдсөн товч материалуудаас та дунджаар хэр уншсан байсан бэ?	
Материалуудыг халт харсан	11.0
Материалын тал хүрэхгүй хувийг нь уншсан	9.2
Материалын бараг талыг нь уншсан	19.6
Материалын талаас илүүг нь уншсан	20.2
Материалыг ихэнхийг нь уншсан	40.1
Сүүлийн хэлэлцүүлэг дуусах үед та товч материалуудаас хэр уншсан бэ?	
Материалуудыг халт харсан	8.2
Материалын тал хүрэхгүй хувийг нь уншсан	6.9
Материалын бараг талыг нь уншсан	12.3
Материалын талаас илүүг нь уншсан	20.8
Материалыг ихэнхийг нь уншсан	51.7

Таны хувьд товч материалын мэдээлэл нь ерөнхийдөө тэнцвэртэй байсан уу эсвэл зарим нэг байр суурийг нь илүү чухалчилсан байсан гэж үзэж байна уу?	
Маш тэнцвэртэй	18.9
Тэнцвэртэй	53.9
Зарим байр суурийг нь илүү чухалчилсан	24.3
Мэдэхгүй	2.8

ⁱ Эм Эм Си Жи компанийн тайлбараар бол анхан шатны судалгааны түүвэрлэлтийг дараахь байдлаар хийсэн: “Бид Улаанбаатар хотын 9 дүүргийн 152 хорооны 1168 хэсгийн жагсаалтаас 8 дүүргийн 150 хэсгийг хэсэг бүрийн өрхийн сууцны төрөлд үндэслэсэн бүлэглэсэн санамсаргүй түүврийн аргаар сонгон авсан. Хэсгүүдийг бүлэглэхдээ гэр хорооллын хэсэг, орон сууцны хорооллын хэсэг гэж бүлэглэсэн. Сонгогдсон хэсгүүдийн өрхийн бүртгэл болон газрын зургийг ашиглан 1500 өрхийг системчилсэн түүврийн аргаар сонгон авсан. Түүвэрт сонгогдсон өрхийн 18 болон түүнээс дээш насны иргэдээс Киш гридийн аргыг ашиглан судалгаанд оролцогчийг сонгон судалгааг авсан”

ⁱⁱ Үнэлгээнд модераторуудын талаар мөн “манай бүлгийн модератор эсрэг талын аргуудыг хэлэлцүүлэхийг дэмжиж байсан” гэсэн асуулт байсан. Зөвхөн 22 хувь нь энэ асуулттай эерэгээр хариулсан байна. Энэ үр дүн нь модераторуудын талаар бусад 3 асуултын үр дүнтэй ихээр зөрчилдөж байна. Бид энэ асуулт оролцогчдыг төөрөлдүүлсэн гэж үзэж байна. Энэ асуултыг модератор өөрийн үзэл бодлыг тулгаж оролцогчдын хэлэлцүүлэгт нөлөөлөх гэж оролдсон эсэх асуултыг яг дараа тавигдсан гэдгийг анхаарна уу (энэ асуултанд оролцогчид маш хүчтэйгээр санал нийлэхгүй байна гэж хариулсан тул төөрөлдүүлсэн байх магадлалтай юм.)

ⁱⁱⁱ Танилцуулга материалд болон хэлэлцүүлгийн үеэр холбогдох хариултыг өгөөгүй учраас долоон асуултын нэгийг нь Мэдлэгийн индекст оруулаагүй бөгөөд энэхүү хүснэгтэнд мөн харуулаагүй болохыг анхаарна уу